

Монгол Улсын ШУА-ийн жинхэнэ гишүүн, түүхийн ухааны доктор, эрдэмтэн Бадамын Лхамсүрэнгийн 80 насны ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурал ШУА-ийн тэргүүлэгчдийн байранд 2003 оны хоёрдугаар сарын 11-нд болов. Эрдэм шинжилгээний бага хурлыг ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, МАХН-ын дэргэдэх Сургалт, судалгааны “Прогноз” төвөөс зохион байгуулав.

Хурлыг Олон Улс Судлалын Хүрээлэнгийн захирал, доктор, профессор Л.Хайсандай нээн удирдаж явуулав. ШУА-ийн дэд ерөнхийлөгч, академич Б.Энхтүвшин нээж, баяр хүргэж үг хэлэхдээ, Монголын түүхийн шинжлэх ухаан, гадаад харилцаа судлалд буурал эрдэмтний оруулсан хувь нэмрийг өндөр үнэллээ. Хурлын үеэр академич Б.Лхамсүрэн гуайд ШУА-ийн Ерөнхийлөгч Б.Чадраа түүний шинжлэх ухааны байгууллагад оруулсан хувь нэмрийг нь өндрөөр үнэлж ШУА-ийн “Хүндэт дэвтэр”-т алдаршуулан бичиж, дээд шагнал “Өргөмжлөл” гардуулав. Мөн МАХН-ын ерөнхий нарийн бичгийн дарга Д.Идэвхитэн үг хэлж, МАХН-ын баярын бичиг, мөнгөн шагналаар шагнасныг гардуулан өгөв.

Хурал дээр Олон улс судлалын хүрээлэнгийн секторын эрхлэгч, доктор, профессор С.Дамдинсүрэн “Б.Лхамсүрэн бол Монгол Улсын түүх, гадаад харилцаа судлалын тэргүүлэх эрдэмтэн мөн”, МАХН-ын дэргэдэх сургалт, сурталчилгааны “Прогноз” төвийн захирал, доктор О.Эрдэнэчимэг “Б.Лхамсүрэн-Монголын төрийн удирдах албанд” гэсэн сонирхолтой илтгэлүүдийг тавьж хэлэлцүүлэв. Б.Лхамсүрэн гуайн шавь нарыг нь төлөөлж доктор, профессор Б.Сумъяа, доктор, профессор Ц.Батбаяр, доктор, профессор Г.Лувсанцэрэн, доктор, дэд профессор О.Батсайхан, доктор Д.Шүрхүү, Олон Улсын Харилцааны Дээд Сургуулийн захирал доктор Н.Алтанцэцэг, улс төр судлаас Д.Ганхуяг нарын хүмүүс үг хэлэв.

ШУА-ИЙН ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ, АКАДЕМИЧ Б.ЭНХТҮВШИНГИЙН БАЯР ХҮРГЭЖ ХЭЛСЭН ҮГ

Нөхөд өө!

Номын садан нараа!

Өнөөдөр бид академич Б.Лхамсүрэн гуайн 80 насны ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж байна.

Б.Лхамсүрэн академич нам төрийн хариуцлагатай албанаа олон жил үр бүтээлтэй ажилласны дотор Шинжлэх Ухаан Дээд Боловсролын салбарт өөрийн эрдэм боловсрол, мэдлэг туршлагаа зориулсан манай нэрт эрдэмтэн билээ. Тэрээр 1960-1962 онд ШУДБ Хорооны дарга, 1961-1962 онд ДТДБХ-ны дарга, 1981-1984 онд Нийгмийн ухааны институтын захирал, 1991 оноос Олон улс судлалын хүрээлэнд ажиллаж бүтээлээ туурвисаар байна.

Тэрээр нэг сэдэвт болон түүх судлалын 6 номын зохиогч, мөн тийм тоооны ном зохиолыг хамтран зохиогч бөгөөд түүх, олон улсын харилцаа, орчин үеийн Монгол Улсын талаар орос, англи хэл дээр хэвлэгдсэн 3 бүтээлийн ерөнхий редактор юм.

Б.Лхамсүрэн гуай Монгол улсын гадаад бодлого, өөрчлөн байгуулалтын онолын баримтлалыг боловсруулах хийгээд Латтимор Монголын тусгаар тогнолын тухай, Монгол-Оросын 90-ээд оны харилцааг үечлэн үзэх асуудал зэрэг онол, сэтгэлгээний 10 гаруй томоохон өгүүлэл бичиж нийтлүүлсэн байна.

Түүний бүтээл, ажил хөдөлмөрийн үр дүнг төрөөс өндөр үнэлэн Алтан гадас, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 3 удаа, 2001 онд Сүхбаатарын одонгоор шагнасан юм.

Академич Б.Лхамсүрэн гуайн гарын шавь, түүний өсгөж бойжуулсан олон арван сэхээтэн шилдэг боловсон хүчнүүд өнөөдөр эх орныхоо оюуны салбарыг хөгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулж байна.

Б.Лхамсүрэн гуай Танд урт нас, эрдэм бүтээлийн дээдийг хүсэн ерөөе.

Б.Лхамсүрэн гуйад 80 насны нь ойг тохиолдуулан ШУА-ийн хүндэт өргөмжлөл өргөн барьсныг ШУА-ийн Ерөнхийлөгч гардуулна.

Анхаарал тавьсанд баярлалаа.